



Оройн Дээд Цагаан Лянхуа Судар

Иж бүрний билигт бодисадвагийн зоригжуулга хэмээх 28-р бүлэг

Тэр цагт дорно зүгийн ертөнцөөс хүмүүст нөлөөлөх харишгүй их хүчтэй Иж бүрний билигт бодисадва олон бодисадвагийн хамт сав ертөнцөд ирэв. Бодисадва нар сав ертөнцийн Тас цогцолсон уулнаа хүрч очингуутаа Шагжамүни бурханд мөргөөд ийнхүү айлтган өчив.

“Аяа Түүнчлэн ирсэн бурхан аа яавал бид Түүнчлэн ирсэнийг нөгчсний хойно Цагаан Лянхуа Судрын жинхэнэ эрдэм буяныг олж авч чадах вэ”

Бурхан бээр дараах дөрвийг хэрэгжүүлэх нь чухал хэмээн айлдав. Нэгдүгээрт би бурханы хамгаалалд байгаа гэсэн бат итгэлтэй байх. Хоёрдугаарт ямагт сайн үйл хийх. Гуравдугаарт зөв сүсэг бишрэлтэй санга нарын чуулганд орох. Дөрөвдүгээрт үргэлж бусдын төлөө зүтгэх. Эдгээр дөрвөн үйлийг зорих нь чухал хэмээв

Иж бүрний билигт бодисадва бээр бурханд дахин айлтган өчив.

“Түүнчлэн Ирсэн бурхан аа их баярлалаа. Би тангаргалаж байна. Би бээр <<Цагаан Лянхуа Судар>>-ын сургаалыг хэрэгжүүлж, тогтоон авагч хүмүүнийг магад сайн хамгаалж, мууд үл ойртуулах болой. Энэхүү судрыг уншин дуудсан хүмүүн байвал тэр хүмүүний өмнө би цагаан зааныг хөлөглөн өөрийн биеэр залраад явдал үйлийг нь хамгаалж, сэтгэлийг нь амгуулах болой. Эдгээр нь гагцхүү Цагаан Лянхуа Судрыг хэрэгжүүлж тогтоон авагч хүмүүнд талархахын тулд болой”

Улмаар Иж бүрний билигт бодисадва бээр бурханы зөвшөөрлийг олоод Цагаан Лянхуа Судрыг хэрэгжүүлж тогтоон авагчийг хамгаалах тарнийн үгсийг айлдав.

Дараагаар нь Иж бүрний билигт бодисадва бээр энэхүү сургаалд итгэж, түгээн дэлгэрүүлэгч хүмүүн нь янз бүрийн эрдэм буян, ач тусыг олдог

тухай айлдав. Тиймээс сургаалыг магад сайн даган хэрэгжүүлэх учиртайг ч бас өгүүлэв.

Иж бүрний билигт бодисадвагийн үгийг сонсон Түүнчлэн Ирсэн Бурхан түүнийг ийнхүү магтав. “Иж бүрний билигт бодисадваа, чи бээр энэ сургаалыг хамгаалж, орчлонд дэлгэрүүлэхэд тусалж, олон амьтанд аз жаргал, эрдэм буяныг олуулах нь гарцаагүй гэж бодож байна. Би бээр Иж бүрний билигт бодисадва чамтай адилхан итгэл бишрэлтэй хүмүүсийг хамгаалан сахия аа” хэмээв. Улмаар сургаалыг тогтоон авч, уншин дуудаад, магад үнэнээр тогтоон цээжилж, номлосон ёсоор нь хэрэгжүүлээд, бичин буулгадаг хүмүүний олох эрдэм буян, ач тусын тухай айлдав.

Төгсгөлд нь Түүнчлэн Ирсэн Бурхан бээр сургаалд итгэж, номлосон ёсоор нь хэрэгжүүлэгч хүн, бурхантай адилхан эрхэм хүндтэй болохыг айлдав.

Бурханы айлтгалыг сонссон бодисадва нар хэмжээлшгүй, хязгаарлашгүй олон амьтдад нөлөөлөх хүчийг олов. Бас хязгаалшгүй олон бодисадва нар Иж бүрний билигт бодисадватай адилхан сургаалыг номлосон ёсоор нь магад сайн хэрэгжүүлэх эрдэм, чадлыг төгс олов. Иж бүрний билигт бодисадва тэргүүтэй хамаг их чуулган бүгдээр машид баясч, бурханы сургаалыг тогтоон авч, хүндлэн мөргөөд өөр өөрийн ертөнц рүү буцацгаав.



Зовлонгийн үндэс

Бодож санасан зүйлс бүтэхгүй байх үед бид зовж шаналдаг. Тийм үед бид голцуу бусдыг буруутгаж, зовлонгоо улам гүнзгийрүүлж орхидог. “Тэрнээс болж л би ийм боллоо, тэр л байгаагүйсэн бол болох байсан юм” гэх мэтээр бодож зовлонгийн үндсэн шалтгааныг олж харалгүй өнгөрөөчихдөг.

Шагжамүни будда энэ талаар Дармапада сударт тодорхой тайлбарласан байдаг:

“Бүх зүйлс сэтгэл дээр тулгуурлаж, сэтгэлээс шалтгаалан үүсэн бий болдог. Хэрэв хүн бохир муу сэтгэлээр ярьж, үйлдэл хийвэл зовлон дагах болно.”

Бусадтай харьцуулан гоё муухай, сайн муу, дээр доор гэж ангиллаж, юманд өрөөсгөл хувиа хичээсэн сэтгэлээр хандах нь “бохир муу сэтгэл” болох ба энэ нь Шагжамүнигийн хэлснээр зовлонгийн үндэс болдог байна.

Тэгвэл тэр хувиа хичээсэн сэтгэл буюу зовлон шаналалын үндэс болдог муу сэтгэл гэдэг нь чухам юу юм бол?

Цагаан лянхуа сударт “Зовлонгийн эх үндэс шунал болой” гэж гардаг ба хэрэгцээт хэмжээнээсээ илүү шунах сэтгэлийг зовлонгийн шалтгаан гэсэн байдаг. Мөн Шагжамүнигийн үлдээсэн сударт: “Шунал ихтэй хүн ашиг хонжоо хөөцөлдөхийн хэрээр зовлон мөн л их байдаг” гэсэн байдаг. Ямартай ч зовлон гэдэг бусдаас авдаг зүйл биш, үнэндээ өөр дотроос бий болдог бололтой.

Жаргалыг ч бид өөрсдөө бий болгоно

Зовж шаналж байх үедээ бид шунал ихтэй, аливаа юманд автамтгай байдаг.



Товчхондоо энэ нь буддизм үүссэн шалтгаан билээ. Тийм учраас зовж шаналахгүйн тулд бид яах ёстойг одоо бол хэн ч гэсэн ойлгож байгаа байх.

Саяны дурдсан сударт: “Шаналал зовлонгоосоо хагацахыг хүсвэл ханахыг мэд”, “Ханахыг мэдэж, шуналаа багасгаваас нирваан болно” гэж бичсэн байдагчилан, хувиа хичээсэн шунал хүслээ жаахан ч гэсэн дарж чадвал зовлон шаналал багасах юм.

Үүнийг ойлгож байгаа хэрнээ хэрэгжүүлж чадахгүй хүн олон байдаг. Сэтгэлд нийцэхгүй зүйлтэй учирсан үедээ “дураараа аашилснаас болсон юм биш

биз?”, “шунал, биеэ тоосноос болсон юм биш биз” хэмээн өөр лүүгээ хандахын оронд зөвхөн үр дүн, өнгөц үзэгдэлд автаж, уурлаж уцаарлан, сэтгэлээр унаж орхидог. Гэвч бид байнга өөрчлөгдөж, хөгжиж байдаг ба сансарын нэгэн бие – хүний хувьд, энэхүү хүсэл шунал нь байгалийн зүйл тул үгүйгэх аргагүй. Гэлээ гээд шуналдаа автагдаж, зовж шаналах нь ухаантай үйлдэл биш билээ.

“Бүх ертөнцийн зарчим” гэсэн Гётегийн үг байдаг:

“Сэтгэл тайван сайхан амьдрах хүсэлтэй бол өнгөрсөн юманд бүү зов, хоосон тэнэг үйлийг бүү тоо, үргэлж одоо байгаа зүйлдээ баярлан талархаж бай, хүнийг бүү ад үз, ирээдүйгээ бурханд даатга”.

Буддизмд бол “Буддад даатга” гэдэг ба хүн талархах сэтгэлээ марталгүй, шунал хүслээ дарж, автамтгай зөрүүд сэтгэлээ

хаяснаар бие сэтгэлээрээ эрүүл саруул амьдарч чадах болно. Жаргалыг ч гэсэн хүн өөрөө бий болгодог гэдгийг санаж явах хэрэгтэй.

“Бүх зүйлс сэтгэл дээр тулгуурлаж, сэтгэлээс шалтгаалан үүсэн бий болдог. Хэрэв цэвэр ариун сэтгэлээр ярьж, үйлдэл хийвэл аз жаргал тэр хүнийг дагах болно”.

Шагжамүни буддагийн судраас ишлэсэн эдгээр үгийн утга нь хүн ганцхан буян үйлдэж байвал аз жаргалтай болдог гэсэн үг биш. Харин аливаа зүйлийг байгаагаар нь хүлээн авч сурвал, хатуу хэцүү зүйл ч гэсэн тэр хүнд аз жаргалын үр болж чаддаг гэдгийг сургаж байна. Үзэл бодол, харах өнцөг гэсэн ганд л зүйлээр бид ийнхүү аз жаргалтай байж чадах юм.

“Косэй” 2013 оны 10 сарын дугаараас



Инээмсэглэл бол тэнгэрийн цэцэг

Рисшо Косей Кай, Удаах ерөнхийлөгч
Нивано Коошёо

Муудалцахын хэрээр дотносдог

Нэгэн сайхан бямба гаригийн өглөө. Том хоёр охин маань өглөө эрт сургуульдаа явж, хоёр бага маань сургууль нь амарч байсан тул гэртээ унтаж байв. Угаасан хувцсаа тагтан дээр тохож байтал унтаж байгаа гэж бодож байсан хүү охин хоёр маань орон дотроо юм ярьж байгаа нь дуулдав. Тэр хоёрын хөөрхөн инээд алдаж байгааг нь сонсоод би ч гэсэн өөрийн эрхгүй инээмсэглэв.

Таван минутын дараа угаалгын өрөөг цэвэрлэж байтал гэнэт хаалга тас хаагдах чимээ сонсогдож, хүү маань пижигнэн гүйж ирэв.

“Өглөөний мэнд, саяхан л инээлдээд байсан чинь яасан бэ?”

гэж хүүгээсээ асуутал:

“Ёстой муухай. Эгч надад ёстой муухай юм хэлсэн”

гээд уруу царайлав. Хэлж амжаагүй байтал охин маань гүйж ирээд:

“Чи өөрөө түрүүлж муухай юм хэлсэн биз дээ”

гэв. Тавхан минутын дотор энэ хоёр маань зад муудалцаад авсан байв.

“За, хүүхдүүд ээ, учраа олохыг хичээгээрэй дээ”

гэж хэлчихээд би цэвэрлэгээгээ үргэжлүүлэв. Тэр хоёр даруй бие биенээ барьж авч ноцолдож эхлэв. Би тэр өдөр хуралтай байсан учраас тэр хоёрын учрыг олж, шүүж байх завгүй байсан юм. Учраа мэдэхгүй хүүдээ юутай ч “хамаагүй зодолдож болохгүй шүү” гэж хэлчихээд яаран ажилдаа явав.

Хурал эхлээд удаагүй байтал гар утас дуугарав. Бага охин маань байв. Ямар нэг юм болсон юм байх даа ...

Утсаа авалгүй байж байтал гурван ч удаа утас дуугарав. Тэгтэл нөхрөөс мэссэж ирэв. Хүү маань халуурч эхэлсэн тул охин маань санаа нь зовж над уруу утасдсан гэнэ. Өдрийн цайгаар гэр лүү утасдтал охин маань:

“Эж ээ, та хурдан гэртээ харь. Маа (бага хүү) бие нь муудаад өрөвдмөөр байна”

“За, ойлголоо, эж нь аль болохоор хурдан харихыг бодно”

гэж хэлтэл охин маань жаахан санаа нь амарсан янзтай байв. Гэтэл тэр өдрийн хурал оройтож, гэртээ харих үед эмнэлэг хаах болчихсон байв. Маргааш нь ням гариг тул эмнэлэг ажиллахгүй. Дотор нь муухай оргих хүүгээ тэврээд ойрын эмнэлэг үрүү яаран



Нивано Кошёо

Рисшо Косей Кайгийн ерөнхийлөгч Нивано Ничикогийн том охин бөгөөд Токио хотод мэндэлсэн.

Хуулч мэргэжлээр их сургуулиа төгссөний дараагаар тус нийгэмлэгийн удирдах албаны мэргэжилтэн бэлтгэх “Такүрин” сургуулийн үндсэн ангид элсэн суралцаж төгссөн.

Өдгөө Цагаан Лянхуа Сударыг судлангаа нийгэмлэгийн гишүүд болон сүсэгтэн олонд ном айлдаж, гадна дотны шашны байгууллагатай хамтран ажиллах тал дээр анхааран ажиллаж байна. Түүнчлэн тус нийгэмлэгийн удаах ерөнхийлөгчөөр сонгогдоод байгаа.

Тэрээр нөхөр Мүнэхиро болон нэг хүү, гурван охины хамт амьдардаг.

гарав. Гэтэл охин маань “Би ч гэсэн хамт явна” гээд эрүүл мэндийн карт, түрийвч, салфетка, алчуур, жижиг төмөн бариад хамт гарав. Гэрийн болон эмнэлэгийн хаалга онгойлгон өгч, эмнэлгийн шаахай хүртэл гаргаж өгөв. Намайг эмнэлгийн бичиг цаас бөглөж байхад охин маань өөрөө шалан дээр сууж, сандал дээр хэвтэж байгаа дүүгийнхээ толгойг илж байв. Өдөржин дүүдээ санаа зовж өнгөрөөжээ гэж бодохоор өөрийн эрхгүй хоёр хүүгээ магтаж:

“Миний хоёр хүү, ёстой их хичээсэн байна”

гэж хэлээд хоёр хүүгээ тэвэрсэн юм.

Эмнэлэгээс гэртээ харих замд хүүг бөөлжихөд охин маань бэлдсэнийхээ дагуу шууд л төмөн, цаас гаргаж ирэн, гэртээ харингуутаа эмээгээ дуудаж ирэв.

Нэгдүгээр ангид орсон хүү маань эгч нартайгаа хамт унтдаг болсон ч, тэр орой надтай хамт унтсан юм. Шөнө жаахан халуурсан боловч маргааш өглөө нь овоо сайжирсан байв. Өглөө эрт унтаж байсан хүүгээ сэрээхгүйн тулд сэмхэн босож бурхандаа идээ будаа өргөв. Тэгтэл шатан дээрээс хэн нэгний хөлийн чимээ сонсогдов. Нэг л хүн бууж ирлээ дээ гэж бодтол “Та бүхэнд өглөөний мэнд хүргэе” гэсэн хоёр хүний дуу сонсогдов. Хартал охин маань дүүгээ үүрчихсэн хоёулаа инээгээд зогсож байв.

Хэрэлдэж муудалцсанаа ор тас мартаж, эгч нь дүүгээ халамжилж, дүү нь эгчийгээ түших нь мэдээжийн зүйл мэт байлаа. Би: “Та хоёр азтай эгч дүүс юм аа”

гэж хэлэхийн зэрэгцээ, энэ агшин бол жинхэнэ нандин эрдэнэ хэмээн бодов.

“Якүшин” 2012 оны 6 сарын дугаараас

“Якүшин” 2012 оны 6 сарын дугаараас

Ёроол үгүй эрдэнэстэй авдар лугаа Цагаан лянхуа судар

Лин Иенфу
Таипэй салбар

2013 оны 5 сард Таипэй нийгэмлэгт бурхан залах ёслолын үеэр тавигдсан илтгэл

Миний бие 1965 онд мэндэлсэн бөгөөд коллежоо төгссөнөөс хойш банкинд ажилладаг байв.

2005 онд нөхөр маань Хятад уруу удаан хугацааны томилолтоор явах болсон тул би ажлаасаа гарч, охиныгоо дагуулаад гэр бүлээрээ Хятадын Сү Зоу гэдэг газар уруу нүүв. Тэндээ охиноо сургуульд оруулав. Гэтэл 2009 онд Жиа Шинг уруу нүүсний дараахан охин маань өвдөж эмнэлэгт хэвтэв. Эмчилгээний орчин нөхцөл хангалтгүй байсан тул 2011 оны 10 сарын 14нд охиноо дагуулаад Таипэй уруу буцахаар болов.

Сэтгэлийг амар амгалан болгож, аливаа зүйлийг зөвөөр харж, мэдэх аргыг зааж өгөх газар байгаа боловчуу хэмээн хайж төрөл бүрийн шашины байгууллагын хаалгыг татав.

Ийнхүү охиныхоо өвчинг хурдан эдгээхийг хүсэж Таипэй дахь Рисшо Косей Кай нийгэмлэг уруу очих болов. Сургаал ном сонсож, нийгэмлэгийн үйл ажиллагаанд оролцох явцад амьдралын мөн чанарыг бясалган бодох болж, өнөө маргаашийн жижиг сажиг бэрхшээлийг алга болгох бус сэтгэл зүрхийг бүрэн чөлөөлөх жинхэнэ авралыг хүсэх болсноор ТУЗ-н дарга Чин, нийгэмлэгийн тэргүүн нараас сургаал сонсох ховорхон боломж олдсон юм.

Коллежид сурч байх үеэс Косей Кай нийгэмлэгийн талаар мэдэж байсан боловч, сургаал ном, дотоод үйл ажиллагааны талаар огт мэддэггүй байв. Сүм дээр очих үед бурханд мэндчилэх төдий байв. Харин одоо бол сүмийхээ номын андууд(санга)тайгаа судар хурж, бурханы төрөл бүрийн үйлд шамдаж байна. Охиндоо бас сургаал сонсохыг хүсэж, бүтэн сайн өдрийн цуглаанд охиноо дагуулан

очиж, хамтдаа судар хурж байгаа.

Түүнчлэн “Оройн Дээд Цагаан Лянхуан сургаал” -ын талаар илүү ихийг мэдэхийн тулд өдөр бүр “Гурван Эрдэнийн Судар”-ыг унших болов.

Энэ жилийн 5 сарын 13 нд Таипэй сүмд бурхан багшийн хөрөг шүтээнийг гардуулах ёслол болно гэдгийг сонсоод маш их баярлав. Энэ боломжийг ашиглан гэртээ бурхан залуулахыг чин сэтгэлээсээ хүсэж байсан боловч Хятадад байгаа нөхөр маань РКК нийгэмлэгийн талаар сайн мэдэхгүй тул эсэргүүцэх вий хэмээн санаа зовинож байв. “Нөхрийг маань зөвшөөрүүлж өгч хайрла” хэмээн чин сэтгэлээсээ залбирч, зуун мянган удаа даймокү дуудав. 4 сард нөхрийгөө Таипэйд ирэх үед хулвас хулвас хийн бурхан залуулах хүсэлтэй байгаагаа хэлэв. Гэтэл нөхөр маань “Чи тэгж хүсэж байгаа бол надад эсэргүүцэх зүйл үгүй” хэмээн зөвшөөрөв. Сэтгэлд буглаад байсан чулууг аваад хаячих



2012 оны 7 сарын 25, Таипэй салбар. Лин Иенфу илтгэл тавьж байгаа нь

Хүлээж авснаар зовлон алга болдог юм байна гэдгийг би ойлгосон юм

шиг санагдав. Өдөр бүр гэртээ судараа хурна гэж бодохоор сэтгэл зүрх догдлон талархаж байв.

Ингээд бурхан залуулах бэлтгэлээ базааж эхлэв. 5 сарын 24нд манай гэрийн бурхан залах ёслолд нийгэмлэгийн тэргүүнээс эхлээд, номын андууд, охин маань сургуулиасаа нэг өдрийн чөлөө хүртэл аван байж оролцов. Бурхан залах үйл ажиллагаа барцад саадгүй тун сайхан болж өнгөрөв.

Одоо бол өглөө оройдоо тогтмол судараа уншиж байгаа. Охин маань хүртэл унших болсон. Бурханаа залуулснаар сэтгэл санаа амгалан тайван болж, түших тулгууртай болсон мэт санагдаж байна. Түүнчлэн “Цагаан Лянхуа судар”-ын талаар илүү мэдэхийг хүсэх болов. Судараа унших тусам “Цагаан Лянхуа судар” нь яг л ёроол үгүй эрдэнэстэй авдар мэт санагдах болов. Ухаад аваад байхад л ёроолоосоо эрдэнэс нь оргилон гарч ирээд, яг л намайг ирж авахыг хүлээж байсан мэт.


Өөрөөр хэлбэл өдөр дутмын амьдралд тохиолдох асуудлуудын хариултыг нь гаргаж өгдөг эрдэнэсийн ном лугаа адил. Косей Кай “эцэг эхийхээ ачийг хариулах, өвөг дээдэстээ зориулж буян үйлдэх, бодьсадвагийн үйлд шамдах” зэргийг үндсэн үйлээ болгон хэрэгжүүлдэг. Сургаалыг хэрэгжүүлэх болсноор ямар нэг асуудалтай тулгарах үед түүндээ хүлэгдээд байлгүй өөдрөгөөр харж чаддаг болсон. Бурхан багш, үүсгэн байгуулагчийн сургаалын дагуу амьдарч, бурханы үйлд улам шамдахыг хүсэж байна. Надтай тохиолдсон сайн муу бүхий л зүйл нь одоогийн надад хэрэгтэй байсан болоод л

бурхан багш илгээсэн хэмээн харж, бодохыг хичээхэд сэтгэл онгойгоод ирэх шиг болдог. Тэр үед “хүлээгээд авчих юм бол зовлон бэрхшээл байсан ч алга болдог юм байна” гэдгийг ойлгосон.

Хойшид эргэн тойрны хүмүүстээ бурханы сургаалын гайхамшигийг мэдрүүлэхийн тулд бүхий хүчин чадлаа дайчлан сургаал түгээх болно гэдгээ тангаргалаж байна. Түүнчлэн “Цагаан Лянхуа судар”-ыг илүү нарийн судалж, бусдын аз жаргал сайн сайхны төлөө амьдрах болно. Бурхан багшийн “Өөрийгөө зул болгон гэрэлтүүж, сургаал (Цагаан Лянхуа) -ыг зул болгон гэрэлтүүлэх” хэмээх сургаалыг марталгүй бурханы үйлд шамдах болно.



Хатагтай Лин Иенфу



Инээмсэглэж ярих нь



“Ерөнхийлөгч дандаа инээмсэглэж байдаг учраас уурлаж байхыг нь хараагүй” гэж намайг хүмүүс хэлдэг боловч би ч гэсэн хүн юм болохоор уур хүрэх үе байдаг. Гэвч уурлалаа гээд зөвхөн өөрөө өөрийнхөө сэтгэлийг шархлуулж, өөрөө л хохирохоос өөр юмгүй билээ.

Ажил үйлс бодож санаснаар бүтэхгүй байх үед эсвэл хэн нэгэн нь өөрийн чинь сэтгэл санааг ойлгож хүлээн авахгүй байхаар гэнэт уур хүрдэг боловч хичнээн чангаар хашгирч уураллаа гээд асуудал шийдэгдэхгүй. Нөгөө хүн нь жаахан тайвширсан юм шиг харагдаж байгаа ч гэсэн үнэндээ бол чин сэтгэлээсээ хүлээн зөвшөөрөөгүй байдаг.

Гэгээрэл гэдэг нь юунд ч автагдахгүй, тогтвортой, амгалан тайван сэтгэлийн түвшинд хүрэхийг хэлнэ. Энэхүү гэгээрлийн байдалд хүрч чадсан Будда өөрийгөө жишээ болгон “Ийм сэтгэлтэй байж чадвал үргэлж баяр баясгалантай, аз жаргалтай байх болно” хэмээн сургасан нь өөрөө бурханы зам мөр билээ.

Амгалан тайван сэтгэлээр ярьвал нөгөө хүн нь ч анхааралтай сайн сонсох болно. Тийм ч учраас би ямагт баяр баясгалантайгаар ярихыг хичээдэг юм.



Буддагийн сургаал бол аз жаргалын амлалт

Өнгөрсөн сард Бангкокт болсон өмнөд Азийн Цагаан Лянхуа судрын семинар болон Таипэй хотод болсон зүүн Азийн цугларалтанд оролцож, сургаалын баяр хөөрийг хуваалцав.

Дэлхийн олон хүмүүстэй уулзаад, бид улс хийгээд соёлын хувьд ялгаатай ч хүн гэдэг утгаараа өөрцгүй гэдгийг мэдэрсэн юм. Хүн бүр бүх зүйл хувирч өөрчлөгдөн, харилцан хамаарч байдаг гэсэн дармагийн дотор бусдын ачаар амьдарч байдаг. Энэ нь нэг утгаараа юмс үзэгдэл нь өөрийн санасны дагуу болдоггүй гэсэн утгатай. Аз жаргалтай болмоор байна гэж хүсдэг нь ч хүн төрөлхтний хувьд адилхан байдаг. Гэвч аз жаргалтай болохын төлөө бурханы билиг оюун хэрэгтэйг ухамсарласан хүн цөөхөн байх бөгөөд зовлонгийн үндсийг өөрөө тарихаг хүн олон байдаг. Дармаг гэгээрсэн Буддагийн сургаал нь бүх хүмүүст хандсан аз жаргалын амлалт юм. Аз жаргалтай амьдрахын тулд олон хүн бурханы сургаалтай учираасай хэмээсэн хүсэл минь дундрашгүй.

РКК, Олон Улсын Хэлтсийн дарга
Мизүтани Шёокоо

SHAN ZAI

Buddha's Wisdom Changes Your Life

Please give us your comments!

We welcome comments on our e-newsletter Shan Zai.

Please send us your comments to the following e-mail address.

E-mail: shanzai.k-international@kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай

Рисшо Косей кай нь 1938 онд Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон Хамтран үндэслэгч Наганума Мёоко нарын санаачлагаар үүсгэн байгуулагдсан. Манай байгууллага нь "Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар"-ын сургаалыг гол номлолоо болгосон эгэл хүмүүс нэгдсэн буддын шашины байгууллага юм. Өөрөөр хэлбэл бурхан багшийн сургаалыг гэр, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлэх замаар дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикогийн удирдлага дор сургаал түгээх үйлсэд зүтгэж, шашны бусад байгууллага болон дэлхийн олон орны хүмүүстэй гар барин, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.



SHAN-ZAI Vol. 97 (October 2013)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс, Хаяг: Fumonkan, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan TEL: 03-5341-1124 FAX: 03-5341-1224 E-mail: shanzai@kosei-kai.or.jp
 Ахлах редактор: Мизутани Шооко, Редактор: Накамура Эцүко, Орчуулсан: Ш.Жаргалмаа, Ж.Гэрэлтуяа, Б.Мөнхцэцэг, А.Бадамхорлоо, Эхийг бэлтгэсэн: Ж.Гэрэлтуяа
 Хэвлэлийн баг: Ёшида Кэй-ичиро, Мацуока Шихо, Мизүмо Кацүтоши, Күдо Юкино, Это Маюми, Сузүки Саюри, Канао Эрико, Макино Эми, Ногава Юриэ, Накаяма Ёшихиро

※Энэхүү сэтгүүл нь Япон, Англи, Хятад, Португал, Тай, Монгол зэрэг 14 улсын хэл дээр тогтмол хэвлэгдэн гарч байна.
 ※Санал хүсэлт, сэтгэгдэл байвал дээрх хаягаар холбоо барина уу.
 ※ Хувийн зорилгоор ашиглах тохиолдолд Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэстэй холбоо барина уу.

Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

2013

Rissho Kosei-kai International

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

4255 Campus Drive, University Center A-245 Irvine,
CA 92612, U.S.A.
Tel: 1-949-336-4430 Fax: 1-949-336-4432
e-mail: info@rkina.org http://www.rkina.org

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Rd. Clearwater, FL 33764, USA
Tel: (727) 560-2927
e-mail: rktampabay@yahoo.com
http://www.buddhismtampabay.org/

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633
e-mail: info@rkhawaii.org http://www.rkhawaii.org

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, U.S.A.
Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, U.S.A.
Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Church of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567
e-mail: rk-la@sbcglobal.net http://www.rkina.org/losangeles.html

Rissho Kosei-kai Dharma Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745
e-mail: dharmasanantonio@gmail.com
http://www.rkina.org/sanantonio.html

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado

Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-6437
e-mail: info@rksf.org http://www.rksf.org

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, U.S.A.
Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261
e-mail: rkseattle@juno.com
http://www.buddhistLearningCenter.com

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of Vancouver

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, U.S.A.
Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499
e-mail: koseiny@aol.com http://rk-ny.org/

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, U.S.A.
Tel & Fax: 1-847-394-0809
e-mail: murakami4838@aol.com http://home.earthlink.net/~rkchi/

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112, U.S.A.
Tel & Fax: 1-405-943-5030
e-mail: ok.risshokoseikai@gmail.com http://www.rkok-dharmacenter.org

Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai Buddhist Center of Klamath Falls
724 Main St., Suite 214, Klamath Falls, OR 97601, U.S.A.
Tel: 1-541-810-8127

Rissho Kosei-kai, Dharma Center of Denver

1571 Race Street, Denver, Colorado 80206, U.S.A.
Tel: 1-303-810-3638

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

446 "B" Patterson Road, Dayton, OH 45419, U.S.A.
http://www.rkina-dayton.com/

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
CEP 04116-060, Brasil
Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377
Fax: 55-11-5549-4304
e-mail: risho@terra.com.br http://www.rkk.org.br

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
CEP 08730-000, Brasil

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongheng District, Taipei City 100, Taiwan
Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433
http://kosei-kai.blogspot.com/

Rissho Kosei-kai of Taichung

No. 19, Lane 260, Dongying 15th St., East Dist.,
Taichung City 401, Taiwan
Tel: 886-4-2215-4832/886-4-2215-4937 Fax: 886-4-2215-0647

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

Rissho Kosei-kai of Pingtung

Korean Rissho Kosei-kai

423, Han-nam-dong, Young-San-ku, Seoul, Republic of Korea
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Pusan

1258-13, Dae-Hyun-2-dong, Nam-ku, Kwang-yok-shi, Pusan,
Republic of Korea
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

Branches under the Headquarters

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,
North Point, Hong Kong,
Special Administrative Region of the People's Republic of China
Tel & Fax: 852-2-369-1836

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

39A Apartment, room number 13, Olympic street, Khanuul district,
Ulaanbaatar, Mongolia
Tel & Fax: 976-11-318667
e-mail: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sakhalin

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk
693005, Russian Federation
Tel & Fax: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai of Roma

Via Torino, 29-00184 Roma, Italia
Tel & Fax : 39-06-48913949
e-mail: roma@rk-euro.org

Rissho Kosei-kai of the UK**Rissho Kosei-kai of Venezia**

Castello-2229 30122-Venezia Ve Italy

Rissho Kosei-kai of Paris

86 AV Jean Jaures 93500 Tentin Paris, France

Rissho Kosei-kai of Sydney**International Buddhist Congregation (IBC)**

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibc-rk.org/>

Rissho Kosei-kai of South Asia Division

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-2850238

Thai Rissho Friendship Foundation

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218
e-mail: info.thairissho@gmail.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-626575

Rissho Kosei-kai of Dhaka

House No.467, Road No-8 (East), D.O.H.S Baridhara,
Dhaka Cant.-1206, Bangladesh
Tel: 880-2-8413855

Rissho Kosei-kai of Mayani

Mayani Barua Paya, Mirsarai, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, Post office road, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Phertali Barua Para, Cox's Bazar, Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Sri Lanka

382/17, N.A.S. Silva Mawatha, Pepiliyana, Boralesgamuwa, Sri Lanka
Tel & Fax: 94-11-2826367

Rissho Kosei-kai of Polonnaruwa**Rissho Kosei-kai of Habarana**

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Galle**Rissho Kosei-kai of Kandy****Branches under the South Asia Division****Delhi Dharma Center**

B-117 (Basement Floors), Kalkaji,
New Delhi-110019, India
Tel & Fax: 91-11-2623-5060
e-mail: sakusena@hotmail.com

Rissho Kosei-kai of West Delhi

A-139 Ganesh Nagar, Tilak Nagar
New Delhi-110018, India

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar,
Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,
Kathmandu, Nepal
Tel: 977-1-552-9464 *Fax:* 977-1-553-9832
e-mail: nrkk@wlink.com.np

Rissho Kosei-kai of Lumbini

Shantiban, Lumbini, Nepal

Rissho Kosei-kai of Singapore**Rissho Kosei-kai of Phnom Penh**

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,
Phnom Penh, Cambodia

Other Groups**Rissho Kosei-kai Friends in Shanghai**

1F, ZHUQIZHAN Art Museum, No. 580 OuYang Road,
Shanghai 200081 China